

12

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙН ЗАРИМ СУДАЛГАА ДҮГНЭЛТ

Б.Сайнжаргал, Л.Оюунцэцэг

Бизнесийн байгууллагыг үнэлэх нэгэн чухал шалгуур үзүүлэлт нь санхүүгийн чадавхи байдаг. Санхүүгийн чадавхи нь аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-ын эдийн засгийн засгийн чадавхийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бизнесийн байгууллагын тухайд зөвхөн төлбөрийн чадвар төдийгүй бизнест оруулсан өөрийн болон зээлийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглан богино хугацаанд нөхөн төлөх, бизнесийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах, бизнесээ өргөтгөн хөгжүүлэх боломжийг илэрхийлсэн өргөн хүрээтэй ойлголт болно. Манай улсын өнөөдрийн практикт бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийг дараахи үзүүлэлтийн системээр хэмжин тооцож үнэлгээ дүгнэлт өгөх боломжтой. Үүнд:

1. Нийт болон өөрийн хөрөнгийн хэмжээ, бүтэц бүрэлдэхүүн
2. Санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадвар
3. Оруулсан хөрөнгийн ашиглалт, эргэц
4. Хөрөнгө оруулалтын өгөөж, ашигт ажиллагаа

Бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийг тодорхойлох арга зүйн асуудлаар 2000 онд хийгдсэн нэгэн сэдэвт судалгаа¹⁴, Үндэсний статистикийн газраас эрхлэн гүйцэтгэсэн “Аж ахуйн нэгж, байгууллагын тооллого-2006” Сангийн яамны бэлтгэсэн “2003-2005 оны Санхүүгийн тайлангийн нэгтгэл”-ийн тоон мэдээллийг ашиглан манай улсын аж ахуйн нэгж байгууллагууд (ААНБ)-ын сүүлийн 10 жил (1996-2005)-ийн ерөнхий дундажийг эдийн засгийн үндсэн салбарууд болон аж ахуйн нэгжийн хэлбэрээр тооцоолж, санхүүгийн чадавхийн хөгжлийн төлөв, байдалд дүгнэлт өгөхийг хичээлээ.

Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын 2006 оны тооллогод бие даасан 32.4 мянган нэгж байгууллага, 2.4 мянган салбар компани хамрагдсан бөгөөд тэдгээрийн 82.3 хувь буюу 26.7 мянга нь аж ахуйн нэгж

¹⁴ Б.Сайнжаргал, Ж.Бат-Өлзий “Бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийн судалгаа” 1996-2000 он

буюу бизнесийн байгууллагууд байжээ. 1998 оны тооллогоос хойшхи 7 жилийн хугацаанд ААНБ-ын тоо 39.7 мянгад хүрч, бараг 2 дахин нэмэгдэн, бизнесийн орчин, ААНБ-ын бүтэц, цар хүрээ, үйл ажиллагааны чиглэлд ихээхэн өөрчлөлтүүд гарсан байна.

ААНБ-ын бүтцийг авч үзвэл 2005 оны эцсийн байдлаар 62.3 хувийг ХХК, 0.9 хувийг ХК эзлэх болж 1998 оноос ХХК-ний хувийн жин 34.9 пунктаар нэмэгдэн, ХК-нийх 1.1 пунктаар буурчээ. Аж ахуйн нэгжүүдийн 98.2 хувийг хувийн өмчийн нэгжүүд эзлэх болсоноор 2005 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 77.4 хувийг хувийн хэвшил бүтээж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 1998 онд 3.5 хувь байсан нь 2005 онд 6.3 хувь, 2006 онд 8 хувьд хүрч, нийт хөрөнгө оруулалт 2 дахин нэмэгдэн, бизнесийн салбарт 4362.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ.

ААНБ-уудын 90 орчим хувь нь 1-19 ажиллагчидтай, 84 хувь нь жилдээ 19 сая хүртэлх төгрөгийн борлуулалттай жижиг болон дунд нэгжүүд байгаа бөгөөд тэдгээрийн өсөлт давамгайлах хандлагатай байгаа дүн гарчээ. Санхүүгийн чадавхийн судалгааны дүнг үндсэн үзүүлэлтүүдээр танилцуулбал:

1. Нийт хөрөнгө, санхүүжилтийн бүтэц. Бизнесийн цар хүрээ өргөжин, санхүүжилтийн хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр активийн удирдлага сайжран, эргэлтийн буюу харьцангуй хөрвөх чадвар сайтай хөрөнгийн хувийн жин, урт болон богино хугацаатай зээл төлбөрийн оролцоо тогтвортой нэмэгдэх хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Аж ахуйн нэгж байгууллагын дүнгээр эргэлтийн хөрөнгийн хувийн жин 1996-2000 оны дунджаар 27 хувь байсан нь 2003-2005 онд 38.4 хувь болж нэмэгдсэн төдийгүй 2005 оны гүйцэтгэлээр бараг 40 хувьд хүрээд байна. 1996-2000 онд нийт санхүүжилтийн 68 хувийг өөрийн хөрөнгө (эзэмшигчийн өмч)-өөр хийж байсан бол 2005 онд 43.6 хувь болон багасаж, гадаад эх үүсвэрийн оролцоо 56.4 хувь болж нэмэгдсэнийг Хүснэгт 1- ээс харж болно.

ААНБ-ын дүнгээр тооцоолсон хөрөнгө, санхүүжилтийн бүтэц (хувиар)

Хүснэгт 1

Үзүүлэлтүүд	Ерөнхий хандлага	2003-2005 оны дундаж	Сүүлийн 3 жил			1996-2000 оны дундаж
			2005	2004	2003	
1 Хөрөнгийн бүрэлдэхүүн						
Эргэлтийн хөрөнгө	өсөх	38.4	39.7	39.3	34.6	27.0
Үндсэн хөрөнгө (цэвэр)	Буурах	56.2	51.8	57.4	62.2	70.0
Бусад хөрөнгө	өсөх	5.4	8.5	3.3	3.2	3.0
Дүн		100	100	100	100	100
2 Санхүүжилтийн бүрэлдэхүүн						
Богино хугацаат өр төлбөр	өсөх	29.6	31.3	31.3	26.3	14.0
Урт хугацаат өр төлбөр	өсөх	26.1	25.1	25.1	27.6	18.0
Эзэмшигчийн өмч	буурах	44.3	43.6	43.6	46.1	68.0
Дүн		100	100	100	100	100

Эх сурвалж: Судалгааний тооцоо

Нийт санхүүжилтанд зээл төлбөрийн оролцоо нэмэгдэн, өөрийн хөрөнгийн нэгжид ноогдох өрийн харьцаа нэгээс их болж байгаатай холбогдон авсан зээлээ хугацаандаа эргүүлэн төлөх хөрөнгийн болоод бизнесийн үйл ажиллагааны баталгаа, бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлэхэд талууд хамтран ажиллах нь чухал боллоо.

Байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны нийт эргэлт, үйлдвэрлэлийн мөчлөгийн хугацаанаас хамааралтайгаар хөрөнгийн болон санхүүжилтийн бүтэц нь эдийн засгийн салбарууд төдийгүй ААН-ийн хэлбэрүүдээр мэдэгдэм ялгаатай байх нь зүйн хэрэг болно. Сүүлийн 3 жилийн зэрэгцүүлсэн судалгаанаас үзвэл эргэлтийн хөрөнгийн хувийн жин барилгын салбарт 56.8 хувь байгаа нь хамгийн өндөр буюу материал багтаамж ихтэй, үндсэн хөрөнгийн хувийн жин эрчим хүчний салбарт хамгийн өндөр буюу 78.5 хувь болж түүний дараагаар ХАА, Уул уурхай, Боловсруулах үйлдвэрийн салбарууд (66.0-61.7 хувиар) орж гарлаа.

Санхүүжилтийн бүтцийн тухайд барилгын салбарын нийт хөрөнгийн 61.4 хувь, Худалдааны салбарт 60.2 хувийг зээл төлбөрөөр буюу гадны эх үүсвэрээр, харин ХАА-н салбарын 52.4 хувь, боловсруулах үйлдвэрт 51.9 хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн нь тус бүрдээ хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Бизнесийн тогтвортой ажиллагаанд эргэлтийн хөрөнгийн хангамж, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийн хүрэлцэхүйц байдал онцгой үүрэгтэй. Энэ үүднээс авч үзэхэд ХАА-н салбарын эргэлтийн хөрөнгийн дүнгээс богино хугацаат өр төлбөр нь 16-29 хувиар илүү, Худалдааны салбарын барааны нөөцийг бараг 100 хувь, эрчим хүчний болон барилгын салбарт эргэлтийн хөрөнгийн 85-95 орчим хувийг богино хугацаат зээл төлбөрөөр санхүүжүүлжээ.

Сонирхолтой дүр зураг бол хөрөнгийн болоод санхүүжилтын бүтэц нь ААН-ийн хэлбэрүүдээр нилээд ялгаатай байгаа явдал юм. Тухайлбал 2002-2005 оны дунджаар Төрийн болон орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газруудын нийт хөрөнгийн 78.4-82.5 хувийг эргэлт удаантай үндсэн хөрөнгүүд эзэлдэг бөгөөд энэ үзүүлэлт хувьцаат компани (ХК)-д 66.2 хувь, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-уудад 51.1 хувь гэж гарсан төдийгүй төрийн өмчийн газруудад өөрийн эх үүсвэр зонхилж (50.8-81.5 хувь), харин ХХК-уудад нийт хөрөнгийнхөө 53 хувийг, ХК-ууд 62.4 хувийг зээл төлбөрөөр санхүүжүүлж байгаа нь харагдлаа.

2. Санхүүгийн чадавхийг илэрхийлэх харьцаанууд. Бизнесийн байгууллагын санхүүгийн чадавхийн өсөлтийг харуулах зорилгоор хамгийн чухал гэж болох 4 бүлэг 14 үзүүлэлтийг цаг хугацааны болон орон зайн (бизнесийн салбарууд ба ААН-ийн хэлбэрээр) зэрэгцүүлэлтээр тооцоолж (хүснэгт 2) ерөнхий хандлагыг тодорхойлов.

Санхүүгийн тогтворжилт. Аж ахуй эрхлэгч байгууллага, нэгжүүдийн үйлдвэрлэл санхүүгийн орчин жилээс жилд сайжран, бизнесийн цар хүрээ, өрсөлдөх чадвар дээшилж судалгаанд хамрагдсан ААНБ-уудын борлуулалтын орлогын цэвэр дүн он тус бүрийн үнээр 2003-2005 онуудад жил тутам 40.7 хувиар өсөж 2005 оны гүйцэтгэлээр 4020.8 тэрбум төгрөгт хүрсэнийг нь тайлангийн нэгтгэлээр гаргажээ.

Бизнесийн ажиллагааны үр дүнг үйл ажиллагааны тогтвортой байдал, түүнийг хангах эх үүсвэрийн хүрэлцэхүйц байдлаар дүгнэдэг нь

зах зээлийн эдийн засгийн нийтлэг жишиг юм. Энэ үүднээс үзвэл Монгол Улсын нийт ААНБ-ын үйлдвэрлэл борлуулалтын тасралтгүй ажиллагааг хангахад зориулагдсан эргэлтийн хөрөнгийн өөрийн санхүүжилтийн хэмжээ 2005 онд 504.4 тэрбум төгрөг болж ойролцоогоор 45 хоногийн гүйлгээг хангахуйц хэмжээнд хүрсэн нь өмнөх онуудаас жил тутам дунджаар 33 хувиар нэмэгдэж ирсэн байна. Үйл ажиллагааны чиглэлээр ХАА-н салбарт өөрийн эргэлтийн хөрөнгө 10.2 тэрбум төгрөгөөр дутагдалтай (сөрөг), харин уул уурхайн болон тээвэр холбооны салбаруудад эргэлтийн хөрөнгийн хангамж хэвийн байгааг судалгаа харуулав.

ААНБ-уудын дүнгээр тооцоолсон Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд

Хүснэгт 2

Үзүүлэлтүүд	Ерөнхий хандлага	2003-2005 оны дундаж	Сүүлийн 3 жил			1996-2000 оны дундаж
			2005	2004	2003	
1. Санхүүгийн тогтворжилт						
Бие даалтын коэф (ӨК/НХ)	буурах	0.443	0.436	0.439	0.461	0.674
Өөрийн эргэлтийн хөрөнгө (тэрбум төг)	нэмэгдэх	419.4	504.4	468.6	285.2	
Өрийн харьцаа (ГК/ӨК)	өсөх	1.257	1.292	1.279	1.16	0.483
2.Төлбөрийн чадвар						
Нөхөлтийн коэф (ЭХ/БХӨ)	тогтвортой	1.297	1.270	1.319	1.318	1.92
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	тогтвортой	0.712	0.721	0.711	0.693	0.86
3.Хөрөнгийн ашиглалт, эргэц						
Нийт хөрөнгийн ачаалал	нэмэгдэх	0.635	0.674	0.614	0.595	0.48
Авлагын эргэц (хоногоор)	удаашрах	84	82	90	79	75
Нөөцийн эргэц (хоногоор)	удаашрах	102	92	114	101	94
Өглөгийн эргэц (хоногоор)	удаашрах	132	137	141	120	
Үйлдвэрлэлийн мөчлөг	удаашрах	186	174	204	180	169
Санхүүгийн мөчлөг	түргэсэх	54	37	63	60	
4. Хөрөнгийн өгөөж (хувиар)						
Нийт хөрөнгийн өгөөж (ЦА/НХ)	нэмэгдэх	2.77	4.41	1.65	1.52	2.48
Өөрийн капиталын өгөөж (ЦА/ӨК)	нэмэгдэх	6.25	10.10	3.76	3.30	2.52
Борлуулалтын ашигт ажиллагаа (ЦА/БО)	нэмэгдэх	4.36	6.54	2.68	2.56	4.54

Эх сурвалж: Судалгааний тооцоо

Аж ахуйн нэгжийн бие даалт (ӨК/НХ)-ын коэффициент жил тутам буурсаар 2005 онд 0.436 болж энэ хэмжээгээр өөрийн хөрөнгийн нэгжид

ноогдох өрийн харьцаа нэмэгдэж байгаа нь шаардагдах нэмэлт санхүүжилтийг гол төлөв зээл төлбөр зэрэг гадаад эх үүсвэрээр санхүүжүүлэх болсныг илтгэж байна.

Төлбөрийн чадвар нь хүлээгдэж байгаа үүрэгт төлбөрүүдийг хугацаанд нь төлж барагдуулахад шаардагдах төлбөрийн хэрэгслийн хүрэлцэхүйц байдлаар тодорхойлогддог. Нөхөлтийн коэффициент жил дараалан буурсаар 1.3 орчимд хадгалагдах болжээ. Нийтлэг жишиг (2:1)-тэй зэрэгцүүлэхэд энэ нь доогуур үзүүлэлт боловч богино хугацаатай зээлийн санхүүжилт зонхилдог манай улсын тухайд ерөнхий дундаж ийм байхыг үгүйсгэхгүй. Тэгэхдээ Уул уурхай, Тээвэр холбоо зэрэг үзүүлэлт өндөр (2.36)-тэй салбарууд ч байна.

Төлбөрийн ойрын боломжийг түргэн хөрвөх хөрөнгийн харьцаагаар тооцоход улсын дундаж 1996-2000 онд 0.86 байсан нь сүүлийн 3 жилийн дүнгээр 0.71 болж ялимгүй буурах хандлагатай байна. Тэгэхдээ ихэнх салбаруудад энэ үзүүлэлт байвал зохих дүнгээс 40-60 хувь доогуур байгаа нь ААНБ-ын төлбөрийн чадвар ерөнхийдөө сул, тэр нь эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэл, үйлдвэрлэлийн мөчлөгийн үргэлжлэх хугацаа, ашгийн түвшин зэрэг олон хүчин зүйлээс хамааралтайг илтгэж байна.

Төлбөрийн чадварын судалгааг зөвхөн өнөөгийн болон ойрын боломжийг тодорхойлсоноор хязгаарлахгүйгээр урт хугацаат зээл, өрийн бичгийн санхүүжилт нэмэгдэхийн хэрээр төлбөрийн хэтийн боломжийг урт хугацаатай санхүүжилтийн оролцоо, тэдгээрийг нөхөх сан нөөцийг бүрдүүлж буй байдалтай нь холбон дүгнэвэл зохино.

Хөрөнгийн ашиглалт, эргэц. Аливаа нөөцийн ашиглалт, бүтээмжийг зөв тооцоолж бодитой дүгнэлт өгөх асуудал судлаачдын анхаарлын төвд байсаар ирсэн. Манай орны эдийн засгийн судалгааны практикт бүтээмжийг голдуу борлуулалтын орлогоор тооцоолж байгаа нь өөр салбаруудад бүтээгдсэн өртгийг агуулсан давхардсан тооцоо юм. Цаашдаа ААНБ-ын хэмжээнд бүтээгдсэн “нэмэгдсэн өртөг”-ийн үзүүлэлтийг тооцоолдог болговол бүтээмжийн өсөлт, түүний хуваарилалтанд бодитой дүгнэлт өгөх боломж бүрэлдэх болно.

Нийт хөрөнгийн ашиглалт 1996-2000 оны дунджаар 48 мөнгө байсан нь тасралтгүй нэмэгдсээр 2003-2005 оны дундаж 63.5 болсон байна. Энэ нь хөрөнгийн амьдралын мөчлөгийн хугацаагаар бодоход чамлахаар бага хэмжээ хэдий ч өсөлт тогтвортой байгаа нь сайшаалтай. Гэхдээ бизнесийн салбаруудаар аваад үзвэл Эрчим хүчний үйлдвэрүүдэд хамгийн өндөр буюу 2.31 төгрөг, ХАА-д хамгийн бага буюу 43.4 мөнгө болж 5.3 дахин зөрүүтэй, ХХК-уудад 79 мөнгө байхад ТӨҮГ-д 34 мөнгө буюу 2.3 дахин доогуур байгаа нь судалгаанаас харагдлаа. Эндээс бизнест оруулсан хөрөнгийн ашиглалтанд үйл ажиллагааны салбарын онцлогоос гадна өмчлөл болон удирдлагын хүчин зүйлүүд нөлөөлж байгааг тэмдэглэвэл зохино.

Эргэлтийн хөрөнгө, авлагын цугларуулалт болон бараа материалын нөөцийн эргэцийн хугацаа нь хөрөнгийн ашиглалтын хамгийн түгээмэл үзүүлэлт төдийгүй тэдгээрийг ашиглан үйлдвэрлэлийн болон санхүүгийн

мөчлөгийн хугацаа, ажлын капиталын (өөрийн эргэлтийн хөрөнгийн) хэрэгцээг тооцоолж, санхүүгийн чадавхийн үнэлгээ дүгнэлтийг гаргадаг.

Бидний судалгаагаар авлагын болон нөөцийн эргэцийн нийлбэрээр тооцсон үйлдвэрлэлийн мөчлөгийн дундаж хугацаа ААНБ-ын дүнгээр 1996-2000 онд 168 хоног байсан нь нэмэгдсээр 2003-2005 онд 186 хоног болж 18 хоногоор удааширчээ. ААНБ-ын 2006 оны тооллогын мэдээллээр тооцоход нийт авлага, өглөгийн 81.1-82.7 хувь хувийн хэвшлийн нэгжүүдэд ногдож байгаа бөгөөд авлагын цугларуулалтын дундаж хугацаа 219 хоног, гэтэл өглөгөө 229 хоногт барагдуулдаг байна. Эндээс харилцагч байгууллагуудын хооронд үүссэн богино хугацаат өр, авлагыг гэрээний нөхцөлийн дагуу хугацаанд нь төлж барагдуулан түншүүдийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлдэг, итгэлтэй харилцагчийн соёлыг төлөвшүүлэх, бас векселийн тооцоог нэвтрүүлэх явдал бизнесийн хөгжилд шаардагдаж байна.

Санхүүгийн мөчлөгийн хугацаа 2003-2005 оны дунджаар 53 хоног болж 3 жилийн өмнөхөөс 20 шахам хоногоор түргэссэний дүнд ойролцоогоор 2 сарын нөөцтэй байхад бизнесийн хэвийн ажиллагаа хангагдахаар байгаа боловч үүссэн өр төлбөрөө хугацаанд нь төлөхгүйгээс харилцагчаа хүндрүүлдэгийг сайн үзүүлэлт гэж хэлэх аргагүй юм.

Салбаруудаар үйлдвэрлэлийн мөчлөгийн хугацаа хамгийн удаан нь барилгад 390 хоног, ХАА 275 хоног, хамгийн түргэн нь тээвэр холбооны салбарт 72 хоног гэж гарсан бөгөөд ХАА, барилга болон бусад хэд хэдэн салбарт ажлын капитал нь “улайдсан”, ААН-ийн хэлбэрийн хувьд ТӨҮГ-д нөөцийн эргэц хамгийн удаан (240 хоног), ХХК-уудад үйлдвэрлэлийн мөчлөг хамгийн түргэн (170 хоног) байгаа нь үйлдвэрлэл, санхүүгийн мөчлөгийн хугацаанд үйл ажиллагааны улирлын шинж, борлуулалтын сувгууд, харилцагчдын төлбөрийн чадвар зэрэг бодит хүчин зүйлүүдээс гадна санхүүгийн удирдлагын нөлөөлөл ч байдаг нь харагдаж байна.

Бизнес оруулсан хөрөнгийн өгөөж. Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж байгууллагын дүнгээр нийт хөрөнгийн нэгжид ноогдох ашиг 1996-2000 онд 2.5 орчим хувь байсан нь 2003-2005 онд 2.8 хувь болж ялимгүй нэмэгдэх хандлагатай төдийгүй өмнөх 5 жилд эзэмшигчдийн өмчийн нэгж тутмаас 3.5 хувийн ашиг олж байсан нь 2003-2005 онд 6.3 хувь болж бараг 2 дахин нэмэгдсэнээр томоохон компаниудын хувьцааны эрэлт нэмэгдэн, нэг бус компаниуд шинээр болон нэмэлт хувьцаа, бас зарим нь өрийн бичиг гарган арилжаалах болсныг тэмдэглэвэл зохино.

Борлуулалтын нийт ашиг сүүлийн 3 жилд ойролцоогоор 30 орчим хувь байгаа боловч орлогын төгрөг тутмаас 4.4 хувийн ашигтай ажилласан байна. Нийт ашгийн хувь хамгийн өндөртэй нь Уул уурхайн салбарт 52.7 хувь, ТӨҮГ-д 62.0 хувь байхад бусад салбарууд ойролцоогоор 17.6-23.9 хувьтай, гэтэл Эрчим хүчний үйлдвэрүүд бүтээгдэхүүнээ өртгөөс нь дөнгөж 5.1 хувийн нэмэгдэлтэй үнээр борлуулж үйл ажиллагааны зардлаа нөхөж чадахгүй алдагдалд ордог юм байна.

ААНБ-ын дүнгээр 2005 онд 750.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь 1998 оныхоос 2 дахин нэмэгдсэн бөгөөд нийт хөрөнгө оруулалтын дүнд дотоодын санхүүжилт 50.4 хувийг, тэр дундаа байгууллагын өөрийн санхүүжилт 31.2 хувийг эзэлж байгаа нь бизнесийн

чадавхи дээшилж байгаагийн илрэл гэж үзэж болно. Хөрөнгө оруулалт илүүтэй хийгдэж байгаа салбарууд нь Уул уурхай олборлох (37.9%), тээвэр холбоо, агуулахын аж ахуй (15.8%), бөөний болон жижиглэн худалдаа (14.1%)-ны салбарууд байна.

Хөрөнгө оруулалтын өгөөжийг бизнесийн салбаруудаар нь авч үзвэл Уул уурхайд оруулсан хөрөнгийн нэгж тутмаас хамгийн их (13 хувь) цэвэр ашиг олж байхад боловсруулах үйлдвэр, ХАА, эрчим хүч, худалдааны салбар 1.7-8.5 хувийн алдагдалтай гарлаа. Ашгийн түвшин түүнд нөлөөлөх хүчин зүйл, нийт ашгийн бодлого, зохицуулалт үйлдвэрийн салбарууд болон ААН-ийн хэлбэрүүдээр харилцан адилгүй байгаа нь бизнесийн байгууллагын ашигт ажиллагааны ерөнхий түвшинд нөлөөлж байна.

Өнгөрсөн 10 орчим жилийн зэрэгцүүлсэн судалгаанаас ерөнхийд нь дүгнэвэл улс орны бизнесийн болон эдийн засгийн орчин сайжрахын хэрээр ААНБ-уудын санхүүгийн тогтворжилт, төлбөрийн чадварын харьцаанууд сайжирсан хэдий ч орлого хуримтлалтын өсөлт нь хөрөнгө оруулалтын өсөлтийг тэр бүр гүйцэж чадахгүй байгаагийн улмаас хөрөнгийн ашиглалт (бүтээмж), оруулсан хөрөнгийн өгөөж дорвитой нэмэгдэхгүй, олонхи салбарууд алдагдалтай ажилласаар байна. Алдагдлын шалтгаан нь салбарын болоод зохион байгуулалтын хүчин зүйлүүдээс голдуу хамааралтай гэж болох авч санхүүгийн хүчин зүйлийн нөлөөлөл багагүй байгааг судалгаа илтгэж байна.

Тухайлбал, ААНБ-ын тооллогын дүнгээр 2006 онд 6100 гаруй ААН-үүд үйл ажиллагаа эрхлээгүй байсан бөгөөд, үүнийхээ үндсэн шалтгааныг 27.5 хувь нь хөрөнгө, санхүүгийн дутагдлаас гэсэн бол суурилагдсан хүчин чадлын дутуу ашиглалтын 35.7 хувийг түүхий эд материал, санхүүжилт, эргэлтийн хөрөнгийн дутагдлаас, 22.5 хувийг бүтээгдэхүүний эрэлт бага байгаагаас шалтгаалсан гэжээ.

3. Санхүүгийн хүндрэлээс сэргийлэх арга зам, зарим санал.

Ийнхүү ААНБ-уудыг, тэр дундаа бизнесийн байгууллагуудын санхүүгийн чадавхийг улс орны хэмжээнд төдийгүй бүс нутаг, үйл ажиллагааны салбарууд, зохион байгуулалтын хэлбэрээр ангилан судалж тухайн нэгжийн хүрсэн түвшин, байр суурийг тодорхойлох нь нэг талаас өөрийн эрхэлж буй бизнесийг бодитой үнэлж, хэтийн зорилго чиглэлээ тодорхойлоход тустайгаас гадна хөрөнгө оруулалтын болон зээлийн эрсдэлээ зөв тооцоолж харилцагчаа сонгох, эцэст нь тухайн бизнесийн үр ашигт шууд болон дам нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлоход ач холбогдол нь оршино. Компанийн үр ашгийн хэлбэлзлийн 35-40 хувь нь улс орны эдийн засгийн байдал, 15-20 хувь нь салбарын дунджаас, үлдэх 40-50 хувь нь өөрийн үйл ажиллагаанаас хамаардагийг судлаачид тогтоосон байдаг. Манай орны тухайд салбарын болоод эдийн засгийн орчны ерөнхий нөлөөлөл дээрхээс илүү л гэхээс багагүй гэдгийг судалгааны дүн харууллаа.

Өөрийн компанийг төдийгүй сонирхож байгаа түншүүд, байнгын харилцагч, зээлдэгчийнхээ санхүүгийн чадавхийг зөв тодорхойлох, тэр мэдээллээ салбарын болон эдийн засгийн дундажтай зэрэгцүүлэн дүгнэлт өгөх нь бизнесийн эрсдэлээс сэргийлэх, нөхцөл байдалд нийцсэн бодитой

шийдвэр гаргахын үндэс болно. Үүний тулд санхүүгийн чадавхид сөргөөр нөлөөлдөг учир шалтгаанууд, урьдчилсан дохиоллын мэдрэмж бизнес эрхлэгчдэд чухал юм.

Санхүүгийн чадавхи сулрах үндсэн шалтгаануудыг:

- Гүйцэтгэх удирдлагуудын сул байдал.
- Санхүүгийн хяналтын системийн оновчтой бус зохион байгуулалт
- Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, борлуулах үнийн зөв бус өрсөлдөөн
- Зардлын бүтэц, бүтээгдэхүүний үнийг нэмэгдэхэд хүргэдэг зардлууд
- Маркетингийн үйл ажиллагаа
- Том компани жижиг компанийг худалдан авах зэргээр тохиромжтой бус нэгдлүүдийг бий болгох зэргээс хамаардаг гэж үзэх нь түгээмэл байдаг.

Санхүүгийн чадавхи сулрахын урьдчилсан дохио олон хэлбэрээр илэрдэг бөгөөд Барууны орнуудад санхүүгийн хүндрэлд орох болзошгүй байдлын дохиолол, магадгүй ойрын үед хүндрэлд орж болзошгүйн дохиолол болох үзүүлэлтийн жагсаалтыг аудитын байгууллагууд ажиглалт, туршлагадаа үндэслэн гаргасан байдаг. Үндсэн ажиллагааны болон санхүүгийн таагүй байдал, тийм байдлын дохиолол болох үзүүлэлтүүдийг ОХУ-ын судлаачид санхүүгийн тайлангийн “хөндүүр” зүйл ангиуд гэсэн нэрээр тодорхойлжээ.

Зээлдэгчийн санхүүгийн чадавхийг дампуурлын болзошгүй байдлын дохиолол болох 5 хүчин зүйлийн Z индексээр үнэлдэг аргачлал бизнесийн практикт хэрэглэгдээд хагас зуун жил болж байна. Санхүүгийн хүндрэлд объектив болон субъектив шинжтэй олон арван хүчин зүйлүүд нөлөөлөх төдийгүй тэдгээрийн нөлөөллийн хүч харилцан адилгүй бөгөөд улс орны эдийн засгийн, тэр дундаа санхүүгийн болон хууль эрх зүйн орчин, компанийн хүчин чадал, эрхэлж буй бизнесийн салбарын онцлог, дохиоллыг эртнээс мэдэрч хариу үйлдэл хийх удирдлагын ур чадвар зэрэг олон зүйлээс хамаардагийг судалгааны дүн харуулж байна.

Бизнесийн чадвар буурахад нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийн хувь оролцоог мэргэжилтнүүдийн судлан тодорхойлсноос үзвэл бараг 80-90 хувь нь эдийн засаг, санхүүгийн хүчин зүйлээс хамааралтайг тогтоосон байдаг. Бидний судалгаа энэ дүгнэлтийг баталж байгаа учир бизнесийн эрсдэлийн зонхилох нөлөөлөл болох эдийн засаг, санхүүгийн орчин, тэдгээртэй холбоотой хүчин зүйлүүдэд илүүтэй анхаарал хандуулж, эрх зүйн зохицуулалт болон шийдвэр гаргахад харгалзан үзэх нь бизнесийн төдийгүй улс орны эдийн засгийн өсөлтийг хангахад тустай. Бизнесийн өсөлт хөгжлийг дэмжиж, санхүүгийн эрсдэлийг бууруулахын тулд:

1. Санхүүгийн тайлангийн мэдээлэлийн сан бүрдүүлж, түүнийгээ бизнес эрхлэгчдэд нээлттэй болгох. Энэ зорилгоор тайлангийн нэгтгэл, түүнд тулгуурласан судалгааг ААНБ-ын нийт дүнгээр болон үйлдвэрлэлийн салбар, аж ахуй эрхлэлтийн хэлбэрүүдээр улирал жилээр гаргаж хэвлэлээр нийтэлдэг зах зээлийн орнуудын жишгийг нэвтрүүлэх шаардлагатай.

2. Аж ахуй эрхлэгчдийн санхүүгийн чадавхи, хөрөнгө оруулалтын

үр ашиг, санхүүгийн нийтлэгддэг тайланд судалгаа хийх үзүүлэлтийн систем, тооцоолох аргачлал журмыг боловсруулан нэг мөр болгох, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчдийг холбогдох мэдээллээр хангах үйлчилгээний “товчоог” зохимжтой хэлбэрээр бий болгон хөгжүүлэх.

3. Банк санхүүгийн байгууллагын зээлжих зэрэглэл, өрийн бичиг болон хувьцаа гаргахаар зөвшөөрөл авч буй компаниудын санхүүгийн чадавхи, ноогдол ашиг болон хүү төлөх чадварын үнэлгээ дүгнэлтийг гаргаж нийтэд мэдээлэх журам, аргачлалыг өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж мөрдөх, улмаар бизнесийн байгууллага, үйлдвэрийн үндсэн салбарын эдийн засгийн үнэлгээний индексийг хамгийн тойм байдлаар ч гэсэн гаргадаг болвол бизнесийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ард нийтийн мөнгөн хуримтлалыг оновчтой байршуулан, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд багагүй тустай алхам болно.